



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Европын Холбоотой
хамтран санхүүжүүлэв



КОВИД-19:

► Цар тахлын үед
хүүхдийн
хөдөлмөрөөс
сэргийлье.



ХҮҮХДИЙН
ХӨДӨЛМӨРИЙН
ЭСРЭГ
ДЭЛХИЙН ӨДӨР
2020 ОНЫ 6 САРЫН 12

КОВИД-19 цар тахал хүүхдийн эрх, аюулгүй байдал болон хөгжилд урьд өмнө үзэгдээгүй эрсдэл учруулж байна. 2020 оны "Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөр"-өөр энэхүү хямралыг даван туулах болон хямралаас гарах явцад улс орнууд, байгууллагууд хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулахыг уриалж байна. Бид зөвхөн энэ цар тахлыг дараад зогсохгүй 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах боломж бий. Үүний тулд бид яг одоо маш өргөн цар хүрээнд шийдэмгий арга хэмжээ авах ёстой.

Дэлхий дахинд нүүрлээд буй КОВИД-19 цар тахал, түүнээс үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хямрал нь хүн амын амь нас, амьжиргаанд маш хүндээр тусаж байна. Нөхцөл байдал хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй энэ үед олон хүүхэд, тэдний гэр бүл боловсрол, сургалтын үйл ажиллагаа нь тасалдах, өвчлөх, өрхийн орлогын эх үүсвэрээ алдах эрсдэлтэй тулгарч байна. Нийгмийн хамгааллын зохистой тогтолцоо бүрдээгүй газарт хүүхэд, гэр бүлийн эмзэг байдал улам нэмэгдэж байна. КОВИД-19 өвчин дэгдэхээс өмнө дэлхий нийтээр бараг 100 сая орчим хүүхдийг хүүхдийн хөдөлмөрөөс хөндийрүүлснээр 2000 онд хүүхдийн хөдөлмөр эрхэлж байсан хүүхдийн тоо 246 сая байсныг 2016 онд 152 сая хүргэж бууруулсан билээ. Эдгээр хүүхдийн 73 сая нь хүүхдэд аюултай ажил эрхэлж байсан юм. Тэгвэл хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй эдгээр хүүхдийн олонх нь өнөөдөр улам илүү эрсдэлд орж, илүү далд хэлбэрийн буюу аюултай ажил эрхлэх, эсвэл илүү олон цагаар ажиллахад хүрч болзошгүй байна. Хямралын уршгаар эмзэг нөхцөлд буй сая сая хүүхэд өрхийн орлогодоо тус нэмэр болох зорилгоор хэт бага насандаа хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй тулаад байна. Ялангуяа охид гэрийн үйлчилгээнд ажиллах буюу хүн гэрээр асрах ажил эрхлэх эрсдэлтэй тулгарч тэр хэрээр осол эндэгдэл, бие махбодын буюу бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй байна. Ажлын байр хомсдож, өрхийн орлого буурахад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, түүний дотор охид илүүтэй өртдөг бэлгийн мөлжлөг нэмэгддэг. Гамшиг, мөргөлдөөн, нэн ядуурлаас дайжиж, эсвэл хүний эрх нь ноцтой зөрчигдсөний улмаас шилжин суурьшсан гэр бүлийн хүүхдүүд үүнд илүү их өртөж байна. Хямралын үед улам даамжирдаг тэгш бус байдал, нийгмийн гадуурхал, алагчлал зэрэг нь нөхцөл байдлыг улам дордуулж байна. Үүний горьц нутгийн уугуул иргэд, үндэстний цөөнх, дотоодын дүрвэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хагас болон бүтэн өнчин хүүхдүүд хамгийн ихээр амсаж байна.

Дэлхий даяар засгийн газрууд цар тахлын тархалтыг хазаарлаж, хор уршгийг нь намжаахад чиглэсэн олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Бид бусдынхаа тэргүүн туршлага, зөв бодлого, шуурхай арга хэмжээнд тулгуурлан үр хүүхдүүддээ илүү сайхан ирээдүйг цогцлоож чадна. НҮБ 2021 оныг "Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын жил" болгон зарласан билээ. Тиймээс энэ жилийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээ, кампанит ажлууд нь НҮБ-ын бүх гишүүн улс, түнш байгууллагууд хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлд хүчээ нэгтгэх боломжийг олгох болно.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэхэд дэлхийн, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн бүхий л түвшинд талууд нягт түншлэн ажиллах шаардлагатай. ТХЗ-ын 8.7 дахь зорилт болох "2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах" зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Эвсэл 8.7 нь олон талын хүчин чармайлтыг ихээхэн үр дүнтэй уялдуулан зохицуулж байна. Энэ хүрээнд замчлагч 21 улс, түншлэгч 250 байгууллага хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, шинэлэг шийдлүүдийг хэрэгжүүлэх, тэргүүн туршлага, сургамжаа хуваалцахыг амлаж, үүрэг хүлээгээд байна. Тухайлбал, Хөдөө аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрийг устгахын төлөөх олон улсын түншлэл, Хүмүүнлэгийн үйл ажиллагаан дахь хүүхэд хамгаалал эвслийн хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх бүлэг зэрэг нь талуудын хамтын ажиллагааны тод жишээ юм.

Дэлхий даяар олон талын гаргаж буй хүчин чармайлтыг зохицуулахад бүс нутгийн байгууллагууд гол үүрэг гүйцэтгэдэг. Жишээлбэл Африкийн холбоо, Баруун Африкийн улсуудын эдийн засгийн хамтын нийгэмлэг, Хүүхдийн хүчирхийллийн эсрэг Өмнөд Азийн санаачилга зэрэг нь хүүхдийн хөдөлмөрийг устгах бүс нутгийн буюу дэд бүсийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гаргасан юм. Хүүхдийн хөдөлмөрөөс ангид Латин Америк, Карибын тэнгисийн орнууд хэмээх бүс нутгийн санаачилгад 30 орны засгийн газар, ажил олгогчид болон ажилчдын төлөөллийн байгууллагууд нэгдсэнээр хамтын ажиллагаанд нь ахиц гарсаар байна. Мөн хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхий нийтийн тэмцэлд улс орнууд, орон нутгийн хүмүүс болон хотууд нэгдэцгээж байна.

"Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын жил"-ийн тойм төлөвлөгөө



Ажил олгогчид, ажилтнууд болон тэдний төлөөллийн байгууллагууд хөдөлмөр эрхлэх явцад тулгарах эрүүл мэндийн эрсдэл, цар тахлын эдийн засгийн үр дагаврыг шийдвэрлэх замаар хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Хямралыг тэнцвэртэй удирдаж, хариу арга хэмжээ авах, улмаар ажилтны эрх, хүүхдийн эрхийг хамгаалж, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад нийгмийн зөвшил нэн чухал үүрэгтэй нь нэгэнтээ нотлогдоод байна.

Бид энэ жилийн дэлхийн өдрийг тохиолдуулан бүх улс орон, түнш байгууллагуудаа “Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын жил”-ийг угтсан үйл ажиллагааг хамтран явуулж, хүчин чармайлтаа нэгтгэхийг уриалж байна. Эдгээр үйл ажиллагаа нь олон улсын жилийн хүрээнд ОУХБ-ын холбогдох конвенц, зөвлөмж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод тулгуурлан хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа буюу эрхлэх эрсдэл бүхий бүх хүүхдийг хамгаалах, КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээнд эдгээр хүүхдэд нэн тэргүүнд анхаарал хандуулахад чиглэх ёстой. Дараах бодлогын зөвлөмжүүд хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэхэд үр дүнгээ өгч байна:

► **Ажилтнууд болон тэдний гэр бүлийг хамгаалж, амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх:** Нийт хүүхдийн хөдөлмөрийн дийлэнх нь (71 хувь) хөдөө аж ахуйд, түүнчлэн ажилчид нь цалинтай амралт авах боломжгүй, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн тэтгэмж, нийгмийн хамгааллын бусад хөтөлбөрт хамрагдаж чаддаггүй албан бус эдийн засагт тохиолдож байна. Бүх ажилтан, ажил олгогч болон тэдний гэр бүлийн гишүүд КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалагдсан байх ёстой. Төрөөс үлэмж хэмжээний дэмжлэг, хөрөнгө оруулалт шаардах хамгааллын арга хэмжээнүүдийг ажлын байранд болон олон нийтийн дунд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Хямралын үед төрөөс хөдөлмөр эрхлэлт, орлогыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх нь маш чухал ач холбогдолтой. Бизнес эрхлэгчид, ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэгчдэд тусах нөлөөг зөөллөх, ажилтнууд ажлын байр, орлогоо шууд алдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авах хэрэгтэй.

► **Бүх нийтийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх:** Хямралын үед өрх, гэр бүлүүд эрүүл мэндийн болон эдийн засгийн цочролыг даван туулахад нийгмийн хамгаалал нэн чухал дэмжлэг болдог. КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн даатгал, нийгмийн хамгаалал амин чухал ач холбогдолтой бөгөөд гэр бүлийн гишүүд өвчлөх буюу амь насаа алдахад хүүхдээ хөдөлмөр эрхлүүлэхээс өөр аргагүй байдалд хүргэхээс сэргийлдэг. Мөн хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэхэд үр дүнтэй нь нотлогдсон нийгмийн хамгааллын бусад арга хэмжээнд мөнгөн тэтгэмж, мөнгөн бус тусламжийн хөтөлбөрүүд (шууд гэр бүлд олгох мөнгөн төлбөр буюу биет тусламж) орж байна. Эдгээр нь өрх, гэр бүлийн орлогын баталгааг хангах, боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжийг нь нэмэгдүүлдэг

► **Төрөөс бүх нийтэд чанартай боловсрол олгох:** Боловсрол хүүхдэд амьдрах ухааны чадвар олгож, ирээдүйд ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Сургуульд сурдаг хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрт өртөх нь бага байдаг. Хямралын үед албан буюу албан бус аль ч хэлбэрээр явагдаж буй боловсрол, сургалтын үйл ажиллагаа тасалдахгүй байх нь маш чухал.

КОВИД-19 цар тахлын улмаас олон улс орнууд сургуулиа хаасан бөгөөд угаасаа бүтэн бус цагаар хөдөлмөр эрхэлж байсан буюу хүүхдийн хөдөлмөрт өртөх эрсдэлтэй байсан хүүхдүүд дахин хэзээ ч сургуульдаа эргэж орохгүй байх магадлалтай. Сургууль хаагдсанаар хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхэлдэг байсан хүүхдүүд сурч боловсрох орчингүй болж, гэр бүлдээ тус нэмэр болох үүднээс илүү олон цагаар ажиллахад хүрч болзошгүй байна. КОВИД-19 цар тахлын үед зайны сургалт нэн чухал ач холбогдолтой болж байна. Гэсэн хэдий ч хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүд компьютергүй, интернэтэд холбогдоогүй, бүр зарим тохиолдолд цахилгаангүйн улмаас зайны сургалтад хамрагдаж чадахгүй байна. Тиймээс тэдгээр хүүхдүүдэд чиглэсэн технологийн хялбар шийдэл бүхий, эсвэл техник технологи шаардагдахгүй хувилбарыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Хямралын үед ямар ч хэлбэрээр боловсролд хамрагдах боломжгүй байсан хүүхдэд боловсролыг нөхөн эзэмшүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авснаар сургуульдаа эргэж ороход нь тусалж чадна. Заавал эзэмших суурь боловсролд бүх нийтийг үнэ төлбөргүй хамруулах нь чухал. Мөн сургуулийн хоол, дүрэмт хувцас, ном, унааны зардал гэх мэт шууд бус зардалд төрөөс дэмжлэг үзүүлэх нь нэгэн адил чухал ач холбогдолтой.

► **Нөлөөллийн үйл ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх:** Хямралын үед эмзэг бүлгийн гэр бүл, хүүхдийг анхаарч, хямралын хариу арга хэмжээний хүрээнд эдгээр хүүхдийн хэрэгцээг нэн тэргүүнд хангахын төлөө холбогдох бүх талуудтай хамтран ажиллах нь юу юунаас чухал болоод байна. Засгийн газар, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлүүд, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын байгууллагууд, бүс нутгийн түншлэгчид болон хэвлэл мэдээллийн байгууллагууд хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч, “зөв” бодлого гаргахыг сурталчлах, нөлөөлөх, түүнд шаардагдах улс төрийн болон санхүүгийн дэмжлэгийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.



Үйл ажиллагааны чиглэл

ОУХБ-ын “2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийг устгах нь” сэдэвт тайланд дараах 6 үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон:

- Хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлд **хууль эрх зүйн хүрээнд** авч буй амлалт үүргийг нэмэгдүүлэх, үүнд нийгмийн зөвшил голлох үүрэгтэйг онцлох;
- Насанд хүрэгчид болон хуульд заасан хөдөлмөрийн насанд хүрсэн залуус **зохистой хөдөлмөр** эрхлэхийг бүх талаар, тэр дундаа албан бус байдлыг шийдвэрлэх замаар дэмжих;
- Өрхийн эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах зорилгоор **нийгмийн хамгааллын** тогтолцоог бүрдүүлэх, өргөжүүлэх;
- Хүүхдийн хөдөлмөрөөс зайлсхийх зайлшгүй нэг нөхцөл болсон төрөөс олгох чанартай, үнэ төлбөргүй **боловсролын** хүртээмжийг нэмэгдүүлэх;
- **Нийлүүлэлтийн** сүлжлэн дэх хүүхдийн хөдөлмөрийг шийдвэрлэх;
- **Эмзэг болон хямралын** нөхцөл байдалд байгаа хүүхдийг хамгаалах.

1 Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1973 оны 138-р конвенц; Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 1999 оны 182-р конвенц; Энх тайван байдлыг хангах, даван туулах чадварыг бэхжүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлт, зохистой хөдөлмөрийг дэмжих тухай ОУХБ-ын 2017 оны 205-р зөвлөмж


Хямралын үед улам чухлаар тавигдаж буй хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудлаар нэгдсэн үзэл баримтлалтай байж, хүүхдийн хөдөлмөрийг шийдвэрлэх нь чухал юм. Эдгээр эрхэд хүүхдийн хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй хүүхдүүдийн эцэг, эхэд зохистой цалин хөлс олгох, хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээ хийх эрхүүд багтдаг. Мөн адил тэгш хандаж, тэгш боломжоор хангах, нас, хүйс, арьс өнгө, шилжин суурьшсан байдал, эсвэл шашин шүтлэгээр нь ялгаварлахаас хамгаалагдах эрх ч ордог. Түүнчлэн албадан хөдөлмөрийг заавал устгах ёстой хүний эрхийн зөрчил гэж үздэг. Хөдөлмөрийн хүрээний эдгээр бүх суурь эрх нь хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг хангаж, хямралаас хүртээмжтэй бөгөөд тогтвортой арга замаар гарах үндсийг бүрдүүлэхэд чухал нөлөө бүхий хүний эрхэд суурилсан, хүүхэд төвтэй хариу арга хэмжээний салшгүй нэг хэсэг юм.

► Та ч бас нэгдээрэй

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг засгийн газрууд, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлүүд, НҮБ-ын байгууллагууд болон хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар ажилладаг бусад олон газрууд өргөнөөр дэмжиж тэмдэглэдэг. Бид таныг болон танай байгууллагыг 2020 оны дэлхийн өдрийн үйл ажиллагаанд нэгдэж, хамтран ажиллахыг урьж байна.

Та хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхий нийтийн тэмцэлд нэгдэж, дуу хоолойгоо хүргэхийг уриалж байна. Нийгмийн сүлжээгээр дамжуулан уг кампанит ажилд хэрхэн оролцох талаар дэлхийн өдөрт зориулсан цахим хуудас(www.ilo.org/ChildLabourWorldDay)-аас танилцаарай. Мөн “Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөр”-ийн хүрээнд танай улсад зохион байгуулахаар төлөвлөж буй үйл ажиллагааны талаар бидэнтэй хуваалцаж, фото зургуудаа илгээгээрэй.

Холбоо барих цахим шуудан: childlabour@ilo.org



КОВИД-19:
Цар тахлын
үед хүүхдийн
хөдөлмөрөөс
сэргийлье.
#хүүхдийнхөдөлмөр

**ХҮҮХДИЙН**
ХӨДӨЛМӨРИЙН
ЭСРЭГ
ДЭЛХИЙН ӨДӨР
2020 ОНЫ 6 САРЫН 12